



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 5/07

Эг

Б. Бадамгаравыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 57 дугаар зүйлийн 57.1, Нийтийн албанд Нийтийн хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 238 дугаар тогтоолын 12 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Норовлин багийн Иргэдийн нийтийн хурлын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 07 тоот тогтоолоор иргэдийн 51,8%-ийн санал авч багийн Засаг даргаар сонгогдон хуульд заасан шаардлагыг бүрэн хангасан тул 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдрөөс томилон ажиллуулсугай.

2. Б. Бадамгаравын үндсэн цалинг 1,458,000 (нэг сая дөрвөн зуун тавин найман мянган) төгрөг, онцгой нөхцөлийн нэмэгдлийг үндсэн цалингийн 30%-иар тооцож олгохыг нягтлан бодогч (Б. Цолмон)-д зөвшөөрсүгэй.

3. Ажил хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үүнд:

Дарга: Д. Бүдханд-ЗДТГ-н даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд: В. Чулуун- Барх багийн Засаг дарга
Б. Номинжаргал-Нярав

4. Норовлин багийн Засаг даргын албан хэрэгцээнд ашиглаж байсан бичиг баримт, эд хогшлыг хүлээлгэн өгч танилцуулахыг комиссын ахлагч (Д. Бүдханд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

БАЛТАНГЭРЭЛ



232501116